

Нягтлан бодогчид шаардагдах мэдлэг, ур чадварыг тодорхойлох нь

Determining the Knowledge and Skills Required for Accountants

Л. Хишигбаяр¹, Э. Ундармаа², Н. Дамдиндорж³, Т. Лагнай⁴

Хураангуй

Хиймэл оюун ухаан, мэдээллийн технологийн хөгжилтэй холбоотой ажлын байранд шаардагдах ур чадвар өөрчлөгдсөөр байна. Ялангуяа нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдийн хувьд ирээдүйд ажлын байраа алдах магадлал өндөр байгааг онцолж, зарим ур чадварыг сайжруулж, тодорхой чиглэлд мэргэших шаардлагатай гэж судлаачид үзэж байна. Иймээс энэхүү судалгаагаар нягтлан бодогч мэргэжилтнүүдэд ажил үүргээ гүйцэтгэхэд ямар мэдлэг, ур чадвар чухал байгаа, цаашид ямар ур чадварыг хөгжүүлэх шаардлагатайг илрүүлэхийг зорьсон. Судалгааны үр дүнд нягтлан бодогчид ажил үүргээ гүйцэтгэхэд санхүүгийн тайлан бэлтгэх, татварын болон хууль эрх зүйн мэдлэг зэрэг мэргэжлийн ур чадвараас гадна техник ашиглах чадвар, харилцааны ур чадвар, багаар ажиллах чадвар, асуудал шийдвэрлэх чадвар зэрэг хувь хүний ур чадварууд хамгийн ач холбогдолтой төдийгүй цаашид ч тасралтгүй сайжруулах шаардлагатай гэж тодорхойлжээ.

Түлхүүр үгс: мэргэжлийн мэдлэг, ур чадвар, техникийн ур чадвар, хувь хүний ур чадвар

Abstract

The skills required for jobs continue to change due to advances in artificial intelligence and information technology. In particular, the researchers believe that accounting professionals are more likely to lose their jobs in the future and need to improve some skills and specialize in certain areas. Therefore, this study aims to find out what knowledge and skills are important for accountants to perform their duties, and what skills need to be developed. As a result of the research, accountants considered that personal skills such as technical skills, communication skills, teamwork skills, and problem solving skills are not only the most important, but also need to be continuously improved in the future.

Keywords: professional knowledge and skills, technical skills, and personal skills

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: khishigbayar@num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: undarmaae@num.edu.mn

³ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: damdindorj.n@num.edu.mn

⁴ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: lagnai@num.edu.mn

Удиртгал

Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ)-ын “Ажил мэргэжлийн ирээдүйн төлөв 2020” тайланд аж үйлдвэрийн 4-р хувьсгал болон техник технологийн хөгжилтэй холбоотой эрэлт буурах мэргэжилд өгөгдөл оруулагч, данс хөтлөгч, нягтлан бодогч, аудитор цалингийн мэргэжилтэн, харин эрэлт нь ихсэх ажил мэргэжилд өгөгдлийн шинжээч, хиймэл оюун ухаан, машин сургалтын мэргэжилтнүүд байна гэж дурьдсан. Мөн хүн ба машин, алгоритмын гүйцэтгэж буй ажлын чиг үүргийн өөрчлөлтөөс шалтгаалаж шинэ технологи дээр ажиллах техник ур чадварууд, хувь хүний бүтээлч чадвар, шинийг эрэлхийлэх ур чадвар, асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх чадвар, уян хатан чадваруудыг эзэмшсэн мэргэжилтний эрэлт, хэрэгцээ нэмэгдэнэ гэж дүгнэжээ.

Нягтлан бодогчид нь байгууллагыг амжилтанд хөтлөх манлайлагч, итгэлт зөвлөгч, стратегийн зөвлөгч болж өөрчлөгдөн ажил олгогч болон үйлчлүүлэгчдээ үнэ цэнэ бий болгохын тулд ирээдүйд мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж байна (Одгэрэл 2021), мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд анхаарч бизнесийн зөвлөх үйлчилгээнд суралцаж, мэргэжлийнхээ үнэ цэнийг нэмэгдүүлэхэд олон талууд хамтарч ажиллах нь дэлхийн чиг хандлагад нийцэх боломжийг олгоно (Наранчимэг 2018), гэж өмнөх судлаачид үзэж байна.

Эндээс харахад өдөр тутмын давтагддаг ажлуудыг автоматжуулснаар нягтлан бодогчийн үүрэг нь стратеги боловсруулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлд шилжиж, бүртгэлийн мэргэжилтнүүд ирээдүйн ажлын байраа хадгалж, техник,

технологийн өөрчлөлттэй хөл нийлүүлэн алхахын тулд тодорхой чиглэлээр мэргэшиж, зарим ур чадваруудыг сайжруулах зайлшгүй шаардлагатай болсныг харуулж байна.

Судалгааны хүрээнд нягтлан бодогчоор ажиллаж буй мэргэжилтнүүдэд ажил үүргээ гүйцэтгэхэд ямар мэдлэг, ур чадвар шаардагдаж, цаашид ямар ур чадварыг хөгжүүлэх нь чухал байгааг илрүүлэхийг зорьсон.

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн ур чадвар нь их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгаар олж эзэмшсэн мэдлэг, ур чадваруудаас бүрдэх бөгөөд түүнийгээ ажлын байранд хэрхэн ашиглаж байгаагаар үнэлэгдэнэ. Өөрөөр хэлбэл мэргэжлийн ур чадвар нь мэргэжлийн нягтлан бодогч мэргэжлийн чадамжаа илтгэн харуулах зорилгоор техникийн чадавх болон мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагатай хослуулан ашигладаг оюун ухааны, хүнтэй харилцах харилцааны, хувийн болон зохион байгуулалтын ур чадварууд бөгөөд мэдлэг, ур чадвар, хандлагын нэгдлийг мэргэжлийн чадамж гэж боловсролын олон улсын стандартад тодорхойлсон (Одгэрэл 2021).

Судлагдсан байдал

Хиймэл оюун ухаан, мэдээллийн технологийн хурдацтай хөгжилтэй холбоотой мэргэжлийн нягтлан бодогчдоор ажиллахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, мэргэжлийн хэтийн төлөв, мэргэжилтэн бэлтгэдэг боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрийн чиг хандлага зэрэг судалгааны ажлууд нэлээд хийгджээ. Тухайлбал:

Цэнд-Аюуш (2018) нь нягтлан бодогч мэргэжилтнүүдэд ур чадвараа дээшлүүлэх

хэрэгцээ байгаа эсэх, байгууллагын зүгээс мэргэжилтний ур чадварыг сайжруулахад хэрхэн дэмжиж ажиллавал зохистой талаар судалсан. Судалгааны үр дүнгээр нягтлан бодогчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах хэрэгцээ байгааг баталж, байгууллагын зүгээс нягтлан бодогчдоо дэмжин сургалтанд хамруулж, ажлын болон сургалтын цагийг уялдуулан зохицуулж өгөх байдлаар дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж үзжээ.

Наранчимэг (2019) судалгаа нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн хөгжлийн түүх, өнөөгийн байдлыг судалсан бөгөөд аж үйлдвэрийн хувьсгалын эрин үед нягтлан бодогч нь зөвхөн нягтлан бодогч төдийгүй мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх, бизнесийн зөвлөх үйлчилгээнд суралцах, мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, дэлхийн чиг хандлагыг дагаж мөрдөж байна.

Хишигбаяр (2019) нар Монгол Улсад ямар чадвар илүү чухал болохыг тодорхойлохын тулд 2016-2018 оны хооронд 153-202 байгууллагын нягтлан бодогчоос асуулга авч ажлын байранд шаардлагатай ур чадваруудыг гүйцэтгэлийн түвшинтэй уялдуулан тодорхойсон. Судалгааны үр дүнгээр нягтлан бодогч нь технологи, зан үйл, харилцааны чадваруудыг сул ашиглаж байна гэж дүгнэсэн.

Dwaase (2020) судалгаагаар оюутнуудын эзэмшсэн мэдлэг, чадамж нь тухайн салбарын мэргэжилтнүүдийн шаардсан стандартад нийцэж байгаа эсэхийг тодорхойлжээ. Энэ бол янз бүрийн салбарын 15 мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаар хийгдсэн чанарын судалгаа юм. Гол сэдвүүдийг тодорхойлохын

тулд цуглуулсан өгөгдлийг кодлож, дүн шинжилгээ хийсэн. Оролцогчид асуудал шийдвэрлэх чадвар, шүүмжлэлтэй сэтгэх, мэдээллийн технологийн бичиг үсгийн мэдлэг, харилцааны ур чадвар зэрэг дараах чадамжуудын ач холбогдлыг онцолсон байна.

Mohamed Saad (2025) хиймэл оюун ухаан өдөр тутмын давтагддаг ажлуудыг автоматжуулж, нягтлангуудыг шинжилгээ хийх, стратеги боловсруулах, зөвлөх үүрэг гүйцэтгэх чиглэл рүү шилжихийг шаардаж байгааг дурьджээ. Мөн энэхүү шилжилт нь шүүмжлэлтэй сэтгэлгээ, харилцааны ур чадвар, технологийн мэдлэг, бүтээлч байдал, дасан зохицох чадвар зэрэг шинэ ур чадваруудыг шаардаж байгааг дурьдсан. Тиймээс нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөртэй дээд боловсролын байгууллагууд сургалтандаа хиймэл оюун ухааныг бодит хэрэглээнд суурилсан сургалтанд нэвтрүүлэх, оюутнуудын шүүмжлэлтэй сэтгэлгээ, хамтын ажиллагаанд суурилсан сургалтыг хөгжүүлэх, нягтлан бодох фирмүүдтэй харилцаа тогтоон шинэ технологийг дагаж мэдлэг, чадварыг шинэчлэх шаардлагатай байгааг дурьджээ.

Судалгааны тоон мэдээ, арга зүй

Судалгаанд нийт 133 нягтлан бодогч оролцсон ба хүйсийн хувьд эмэгтэй оролцогчид 81.2%, эрэгтэй оролцогчид 18.8%-г эзэлж байсан. Судалгаанд оролцогчдыг төгссөн сургуулийн хувьд авч үзэхэд 45.9% нь дотоодын төрийн өмчийн их, дээд сургууль, 47.4% нь дотоодын хувийн өмчийн их, дээд сургууль, 6% нь гадаадын их, дээд сургууль төгссөн байна. Судалгаанд оролцогчдын нягтлан бодогчоор ажилласан туршлагыг харахад нийт оролцогчдын 28.6% нь 3 хүртэл жил,

11.3% нь 3-6 жил, 15% нь 7-10 жил, 18.8% нь 11-15 жил, 26.3% нь 15-аас дээш жил ажилласан оролцогчид тус тус эзэлж байна.

Асуулгын эхний хэсэгт судалгаанд оролцогчдын ажлын туршлага, нас, хүйс, төгссөн сургууль, ажилладаг салбар, байгууллагын аль түвшинд ажилладаг зэргийн тодруулсан. Дараагийн хэсэгт ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах ур чадварыг 1) мэргэжлийн ур чадвар, 2) техникийн ур чадвар, 3) функциональ ур чадвар, 4) хувь хүний ур чадварууд, 5) алба, нэгжтэй хамтран ажиллах чадвар гэсэн хэсгүүдээр задлан асуусан бол сүүлийн хэсэгт цаашид ажлын байраа хэвээр хадгалах болон албан тушаал дэвшихэд шаардагдах мэдлэг, ур чадварыг илрүүлэх, тэдгээр ур чадварыг хөгжүүлэх боломжит арга замыг тодруулсан.

Судалгааны асуулгыг Likert scoring ашиглан 1-5 хүртэл оноо (ач холбогдол өндөр бол 5 оноо г.м)-оор үнэлүүлж, үр дүнг SPSS 25 программ ашиглан боловсруулсан.

Судалгааны үр дүн


Судалгааны эхний хэсгийн зарим үр дүн болох судалгаанд оролцогчдын ажлын туршлага, ажиллаж буй салбарыг Зураг 1-т харууллаа.

Судалгаанд оролцогчдын ажлын туршлагыг харахад 28.6% нь 3 хүртэл жил, 11.3% нь 3-6 жил, 15.0% нь 7-10 жил, 18.8% нь 11-15 жил, 26.3% нь 15-аас дээш жил ажилласан оролцогчид байна. Үүнээс харахад 3 жил хүртэл болон 15-аас дээш жил ажилласан ажилтнууд бусад бүлэгтэй харьцуулахад илүү олон байсан.


Ажилладаг салбарын хувьд хувийн хэвшил болон төрийн байгууллагад ажилладаг ажилтнууд 94.7% буюу дийлэнх хэсгийг эзэлж байгаа бол төрийн бус байгууллага, боловсрол болон бусад салбарт ажилладаг ажилтнууд 5.3%-г эзэлж байна.

Зураг 2-т харуулснаар судалгаанд оролцогчдын мэргэшлийн зэргийг давхардсан тоогоор авч үзвэл, мэргэшсэн нягтлан бодогч 35, мэргэшсэн үнэлгээчин 1, мэргэшсэн удирдлагын нягтлан бодогч 6, татварын мэргэшсэн зөвлөх 9, аудитор 5, АССА 1, ямар нэгэн мэргэшлийн зэрэг аваагүй 91 оролцогч тус тус оролцсон


Зураг 1. Ажилласан жил, ажилладаг салбар



Зураг 2. Мэргэшлийн зэрэг



Зураг 3. Ур чадвараа сайжруулсан байдал



байна. Түүнчлэн давхар мэргэшлийн зэрэгтэй 10 оролцогч, гурван давхар мэргэшлийн зэрэгтэй 3 оролцогч тус тус байсан.

Зураг 3-аас харахад оролцогчдын 34% буюу 1/3 нь мэдлэг, ур чадвараа бие даан сайжруулан хөгжүүлдэг бол цахим сургалт болон бусад сургалтаар ижил 16.6%, ММНБИ сургалтаар 15.4%, ТМЗ нийгэмлэгийн сургалтаар 9.1%, магистр болон докторын мэргэжил дээшлүүлэх сургалтаар 8.3% нь тус тус өөрийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлж байна.

Хүснэгт 1-ээс харахад судалгаанд оролцогчдын 5.3%, удирдлагын түвшинд буюу захирал, дэд захирлаар 88.7% нь тооцооны нягтлан бодогч, ахлах болон ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж, 6.0% нь мэргэжлийн бус ажил эрхэлж байна.

Хүснэгт 2-т судалгаанд оролцогчдын хувьд их, дээд сургуулийн хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвар нь практиктэй хэр нийцэж байсныг тодруулсан. Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 21.2% нь 5, 21.8% нь 4, 39.8% нь 3 оноо өгч, дунджаар 3.45 гэж үнэлэгдсэн нь их, дээд сургуулиас олж авсан мэдлэг, ур чадвар нь практикт дунд болон дунджаас дээш түвшинд ашиглагддаг гэдгийг харуулж байна.

Зураг 4-өөс харахад үндсэн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадварт санхүүгийн тайлан бэлтгэх нь хамгийн чухал гэж үнэлэгдэн дунджаар 4.61 оноо авсан бол татварын хууль, зохицуулалтын мэдлэг 4.34, аудит болон баталгаажуулалтын мэдлэг, ур чадвар нь 4.09 буюу чухал гэж үнэлэгдсэн


Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын байгууллагад ажилладаг түвшин

	Давтамж	Эзлэх хувь
Удирдлагын түвшин (захирал, дэд захирал)	7	5.3
Санхүүгийн мэргэжилтэн (ерөнхий ба ахлах нягтлан бодогч, хөрөнгө оруулалтын зөвлөх, санхүүгийн шинжээч)	78	58.6
Мэргэжилтэн (тооцооны нягтлан бодогч, данс хөтлөгч)	40	30.1
Бусад	8	6.0


Хүснэгт 2. Их, дээд сургуулийн хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадварын хэрэглээ

Үзүүлэлт	1 оноо	2 оноо	3 оноо	4 оноо	5 оноо
Давтамж	10	13	53	29	28
Эзлэх хувь	7.5	9.7	39.8	21.8	21.2
Дундаж оноо	3.45				

Зураг 4. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадвар, дундажаар



Зураг 5. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хувь хүний ур чадвар, дундажаар




байна. Харин төсөв боловсруулах болон урьдчилан таамаглах чадвар нь 3.71-3.91 оноогоор дунджаас дээш ач холбогдолтойд тооцогджээ. Дээрхээс харахад их дээд сургуулиас эзэмшсэн мэргэжлийн ур чадвар нь ажил үүргээ гүйцэтгэхэд чухал болох нь харагдаж байна.

Зураг 5-д судалгаанд оролцогчдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хувь хүний ур чадваруудыг тодрууллаа. Судалгаанаас харахад харилцааны ур чадвар, асуудал шийдвэрлэх, чадвар, цагийн менежменттэй байх чадварыг маш чухал гэж үзэн 4.5-аас дээш үнэлгээ өгсөн байна. Энэ нь багийн ажиллагаа, харилцан ойлголцол, үйлчлүүлэгчтэй ажиллах чадвар, цаг төлөвлөлт зэрэг нь ажил үүргээ гүйцэтгэхэд чухал ач холбогдолтойг харуулж байна. Харин


дасан зохицох, задлан шинжлэх, сэтгэл хөдлөлөө удирдах чадваруудыг 4.0-с их 4.5-аас багаар үнэлсэн ч ач холбогдолтойд тооцож байна.

Зураг 6-аас харахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 93.2% нь ажил үүргээ гүйцэтгэхэд нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашиглах ур чадварыг ач холбогдолтой гэж үзээд дунджаар 4.66 оноогоор үнэлсэн байна. Харин ERP болон хиймэл оюун ухаан, машин сургалтын ур чадварыг дунджаар 4.0-4.1 оноогоор үнэлж чухал ач холбогдолтойд тооцсон. Харин 65.2% нь blockchain ашиглалтын ур чадваруудыг харьцангуй бага ач холбогдолтойд тооцож дунджаар 3.26 оноогоор үнэлсэн байна. Эндээс харахад уг технологийн хэрэглээ сул байгааг харуулж байна.


Зураг 6. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах техникийн ур чадвар, дундажаар



Зураг 7. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах функциональ ур чадвар, дундажаар



Зураг 8. Бусад хэлтэс, нэгжтэй хамтран ажиллах чадвар, дунджаар



Зураг 7-д судалгаанд оролцогчдоос тодорхой чиглэлээр илүү мэргэшиж хөгжүүлэх шаардлагатай функциональ ур чадваруудыг тодруулахад хууль эрх зүй болон нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системийг удирдах мэдлэг, ур чадвар нь хамгийн өндөр ач холбогдолтойд тооцогдож 4.5-аас дээш үнэлэгдсэн байна. Санхүүгийн шинжилгээ, дотоод хяналт, эрсдлийн үнэлгээ гэсэн ур

чадваруудыг ч бас чухал гэж үзэж 4.0-өөс их 4.5-аас багаар үнэлжээ. Харин стратеги сэтгэлгээний ур чадварыг хамгийн бага буюу 3.98 оноогоор үнэлсэн байна.

Зураг 8-аас үзэхэд судалгаанд оролцогчдын хувьд ажил үүргээ гүйцэтгэхэд хамтран болон багаар ажиллах чадварыг хамгийн ач холбогдолтойд тооцож дунджаар 4.73 оноогоор үнэлсэн байна. Албан бичгийн ур чадвар, өөрчлөлтийн удирдлага, ажил

Зураг 9. Цаашид сайжруулах шаардлагатай байгаа ур чадвар, дунджаар



Зураг 10. Сайжруулах шаардлагатай байгаа мэргэжлийн ур чадвар, дундажаар



хэрэгч хандах чадварыг ач холбогдолтойд тооцож 4.0-өөс их 4.5-аас багаар үнэлжээ. Энэ нь ажлын орчинд хамтын ажиллагаа, нөхцөл байдал, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, албан ёсны харилцааны ур чадварууд чухал гэдгийг харуулж байна.


Зураг 9-өөс харахад судалгаанд оролцогчид цаашид ажлын байраа хадгалж үлдэхэд дээрх ур чадваруудыг бүгдийг нь хөгжүүлэх шаардлагатай гэж үзсэн ч технологи ашиглах чадвар, багаар ажиллах чадвар, харилцааны ур чадваруудыг хамгийн өндрөөр үнэлсэн нь өмнөх судалгааны үр дүнтэй ижил үр дүнг харуулж байна (Хишигбаяр, 2019).

Зураг 10-аас харахад мэргэжлээрээ тогтвортой ажиллахад дээр дурдсан мэдлэг, ур чадваруудыг бүгдийг нь сайжруулах нь ач холбогдолтой гэж

үзжээ. Эдгээрээс татварын бүртгэл болон хууль эрх зүйн мэдлэг нь 4.5-аас дээгүүр үнэлэгдсэн нь хуулийн өөрчлөлтөөс шалтгаалж нэн түрүүнд эдгээр мэдлэгийг сайжруулах хэрэгцээ гардгийг харуулж байна. Бусад мэдлэг, ур чадварын хувьд 4.0-өөс их 4.5-аас багаар үнэлэгдсэн ч үндсэн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага их байгааг илтгэж байна.

Зураг 11-т судалгаанд оролцогчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх боломжийг харуулсан. Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 56% нь мэргэжлийн байгууллагын сургалт, 27% нь бие даан суралцах нь мэдлэг, ур чадвараа сайжруулах боломжтой гэж үзсэн байна. Харин бусад сургалтыг харьцангуй бага хувиар үнэлжээ. Энэ нь судалгаанд

Зураг 11. Мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх боломж



Зураг 8. Нэг салбар нэгжид ноогдох ажиллагсдын дундаж тоо, аймгаар, 2022 он

Хүснэгт 3. Мэдлэг, ур чадварын үнэлгээний ялгаатай байдал, салбараар

	Ажилладаг салбар	Түүврийн тоо	Дундаж оноо	p утга
Төсөв зохиох, урьдчилан таамаглах	Хувийн хэвшил	65	3.65	0.025
	Төрийн байгууллага	54	4.19	
	Төрийн бус байгууллага	3	4.67	
	Бусад	2	4.00	
Өртгийн удирдлага	Хувийн хэвшил	67	3.88	0.036
	Төрийн байгууллага	53	3.47	
	Төрийн бус байгууллага	3	5.00	
	Бусад	2	2.50	

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

оролцогчдын хувьд мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэй сургалт болон хувь хүний идэвх санаачилга нь тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хамгийн боломжит арга зам гэдгийг илэрхийлж байна.

Хүснэгт 3-т судалгаанд оролцогчдын ажилладаг салбараас шалтгаалан тэдний мэргэжлийн ур чадваруудыг чухалчлан үнэлэх байдал ялгаатай эсэхийг One-Way ANOVA тест ашиглан шинжилсэн. Үр дүнгээс харахад үндсэн ур чадварууд болох төсөв зохион, урьдчилан таамаглах, өртгийн удирдлага гэсэн хоёр чадваруудад ялгаатай үнэлгээ өгсөн байна. Тухайлбал, төсөв зохион урьдчилан таамаглах ур

чадварыг төрийн байгууллагын нягтлан бодогчид хувийн хэвшлийн нягтлан бодогчдоос илүү чухал гэж үнэлсэн. Харин өртгийн удирдлагын ур чадварыг бусад салбарт ажиллаж буй хоёр оролцогч чухал биш ур чадвар гэж үнэлсэн байна.

Хүснэгт 4-өөс харахад судалгаанд оролцогчдын ажиллаж буй түвшин буюу албан тушаалын зэрэглэлээс шалтгаалан ур чадваруудыг ялгаатай үнэлдэг эсэхийг судлахад дээрх чадваруудад ялгаатай үр дүн илэрсэн байна. Тухайлбал аудит баталгаажуулалтын чадварыг санхүүгийн мэргэжилтэн түвшинд ажилладаг ажилтнууд удирдлага болон бусад түвшинд ажилладаг хүмүүсээс илүү чухал

Хүснэгт 4. Мэдлэг, ур чадварын үнэлгээний ялгаатай байдал, ажиллаж буй түвшнээр

	Ажилладаг салбар	Түүврийн тоо	Дундаж оноо	р утга
Үндсэн ур чадвар				
Аудит баталгаажуулалт	Удирдлага	7	3.43	0.037
	Санхүүгийн мэргэжилтэн	71	4.25	
	Мэргэжилтэн	35	4.06	
	Бусад	7	3.29	
Өртгийн удирдлага	Удирдлага	7	3.43	0.022
	Санхүүгийн мэргэжилтэн	74	3.61	
	Мэргэжилтэн	36	4.17	
	Бусад	8	2.88	
Техник ур чадвар				
НББ-ийн программ	Удирдлага	7	3.57	0.000
	Санхүүгийн мэргэжилтэн	76	4.76	
	Мэргэжилтэн	40	4.75	
	Бусад	6	4	
Сайжруулах ур чадвар				
Тасралтгүй суралцах чадвар	Удирдлага	7	3.86	0.029
	Санхүүгийн мэргэжилтэн	76	4.53	
	Мэргэжилтэн	38	4.63	
	Бусад	8	4	
Сайжруулах мэдлэг				
Хууль эрх зүй	Удирдлага	7	4	0.025
	Санхүүгийн мэргэжилтэн	74	4.73	
	Мэргэжилтэн	37	4.54	
	Бусад	8	4.25	

Эх сурвалж: Судлаачдын тооцооллоор

хэмээн үнэлсэн байна. Харин өртгийн удирдлагын ур чадварыг мэргэжилтэн түвшний нягтлан бодогчид илүү өндрөөр үнэлсэн байна.

Харин техник ур чадварын хувьд НББ-ийн программ дээр ажиллах чадварыг удирдлагын түвшинд ажилладаг оролцогч бусадтай харьцуулахад илүү багаар үнэлсэн байна. Сайжруулах ур чадвар болон мэдлэгийн хувьд тасралтгүй суралцах чадвар болон хууль эрх зүйн мэдлэгийг санхүүгийн мэргэжилтэн болон мэргэжилтэн түвшний ажилтнууд удирдлагуудаас илүү чухал хэмээн үнэлжээ.

Дүгнэлт

Судлаачид техник, технологийн хөгжилтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдэд технологи ашиглах, харилцааны, асуудал шийдвэрлэх, дасан зохицох, задлан шинжлэх, болон шүүмжлэлтэй хандах зэрэг ур чадварууд чухал гэдгийг онцолж байна.

Судалгааны үр дүнгээс харахад ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадварт санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэлийн программ ашиглах ур чадвар, татварын бүртгэл болон хууль эрх зүйн мэдлэг чадварууд чухал байна. Хувь хүний ур чадварын хувьд харилцааны ур чадвар, хамтран болон багаар ажиллах

чадвар, асуудал шийдвэрлэх чадвар ач холбогдолтой байна.

Цаашид татварын бүртгэл болон хууль эрх зүйн мэдлэг, технологи ашиглах чадвар, харилцааны ур чадвар, асуудал шийдвэрлэх ур чадвар, багаар ажиллах чадвар зэрэг хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэх шаардлагатай байна.

Мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг сайжруулахад мэргэжлийн байгууллагуудын сургалтууд чухал үүрэг гүйцэтгэж, цаашид ч энэ арга замаар болон бие даан сурах нь мэдлэг, ур чадварыг сайжруулах гол хөшүүрэг болох нь харагдаж байна.

Ашигласан материал

- Dwaase, D. A., Awotwe, E., & Obese, E. (2020). Skills Requirements of the Professional Accountant in a Changing Work Environment. *IOSR Journal of Humanities and Social Science*, 25(12), 12-17.
- Mohamed Saad, A. M. A. (2025). Adapting Accountants to the AI Revolution: University Strategies for Skill Enhancement, Job Security and Competence in Accounting. *Higher Education, Skills and Work-based Learning*, 15(2), 290-305.
<https://doi.org/10.1108/HESWBL-10-2023-0295>
- Наранчимэг, Л. (2018). Нягтлан бодох бүртгэлийн (НББ-ийн) мэргэжлийн өнөө ба ирээдүй. *Journal of Accounting Theory and Practice*, 2(4), 297-301.
- Одгэрэл, А. (2021). Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн өөрчлөлт ба ирээдүйн чиг хандлага. *CPA plus Mongolia*, 4(14), 37-42.
- Хишигбаяр, Л, & Лхагвасүрэн, Д. (2019). Цахим эрин үеийн нягтлан бодогчдод шаардагдах ур чадварын асуудалд. *Journal of Accounting Theory and Practice*, 3(2), 117-122.
- Цэнд-Аюуш, Г. (2018). Нягтлан бодогчдын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих замаар ур чадварыг сайжруулах нь. *Journal of Accounting Theory and Practice*, 2(4), 313-328.